

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН
ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, САНАЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН
2022 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН МЭДЭЭ

2022.09.27.

2022 оны 3-р улирлын байдлаар Засаг даргад 33, Засаг даргын Тамгын газарт 1, иргэний бүртгэлийн асуудлаар 173, нийт 207 өргөдөл хүлээн авсан. Иргэдээс ирүүлсэн 207 өргөдөл, гомдол, саналыг Засаг дарга болон ЗДТГ-ын бүрэн эрх, эрхлэх асуудлын хүрээнд шийдвэрлэж ажилласан.

Засаг дарга болон ЗДТГ-т нийт 207 өргөдөл ирсний 173 өргөдөл буюу 83,6 хувь нь иргэний бүртгэлтэй холбоотой асуудлаар, 34 өргөдөл буюу 16,4 хувь нь бусад өргөдөл эзэлж байна.

Засаг даргын Тамгын газарт иргэдээс ирсэн өргөдөл, гомдол, санал шийдвэрлэлтийн талаар авсан арга хэмжээ:

Нэг: Иргэний бүртгэлийн асуудлаар нийт 173 иргэний өргөдөл ирснийг хугацаанд нь шийдвэрлэсэн. Үүнд:

1. Шинэ төрсөн хүүхэд - 31
2. Гэрлэлт – 5
3. Гэрлэлт цуцлалт - 1
4. Нас баралт - 10
5. Иргэний үнэмлэхтэй холбоотой - 71
6. Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой - 55

Хоёр: Бусад 34 өргөдөл ирсэн. Үүнд: Мод үржүүлгийн талбай байгуулах газар хүссэн 1 өргөдөлд МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд томилогдсон ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж тус иргэнд 2 га газрыг мод үржүүлгийн зориулалтаар ашиглуулахаар шийдвэрлэсэн. Нийтийн эзэмшлийн орон сууцны байрны дээврээс ус гоожсон тухай 1 өргөдөл ирсний дагуу тухайн газрын нөхцөл байдалтай нь багийн Засаг дарга танилцаж, чиглэл өгсний дагуу “Тохилог сууц” СӨХ болон оршин суугаа иргэд хамтран ус гоожсон газрыг тогтоож, засварлан, арга хэмжээ авч ажилласан байна. Тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах тухай 1 өргөдлийг сумын Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/31 дүгээр захирамжаар тусгай зөвшөөрлийн хугацааг 2 жилээр сунгасан. Коронавируст халдвар (Ковид-19)-ын хөл хорионы нөхцөл байдлаас шалтгаалан үйл ажиллагаагаа түр хугацаанд явуулаагүй тул Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлттэй холбоотой асуудлыг Монгол банкны найдвартай зээлдэгч жагсаалтаас хасаж өгөхийг хүссэн иргэний өргөдлийг сумын ИТХ-ын хуралдаанд танилцуулж, хуулийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй тул

зээлийн эргэн төлөлтийг нөхөн төлүүлэхээр хариуг өгсөн. Хашаан дотор тарьсан моднуудыг усалж өгөх тухай өргөдөлд иргэний хувийн өмчлөлийн газрын хашаан дотроо тарьсан модыг усалж өгөх боломжгүй тухай хариуг өгсөн. Ногоо тариалах хүлэмжний дэмжлэг хүссэн 4 иргэний өргөдлийн дагуу аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 3 иргэнийг хүлэмжээр хангаж, 1 иргэн төсөлгүй байсан тул хүлэмжний дэмжлэгт хамрагдаагүй. РС тоглоомын газрын үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулахыг хүссэн тухай өргөдөлд үйл ажиллагааг халдвар хамгааллын дэглэмийг чандлан баримталж, үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг олгосон. Эзэмшлийн тариалалтын талбайд гүний цэвэр усны ахуйн зориулалтын худаг гаргаж өгөх, мөн ногоо тариалах хүлэмжний дэмжлэг хүссэн 1 иргэний өргөдлийн дагуу “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумаас хүлэмжний дэмжлэг үзүүлж, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт худаг гаргаж өгөх тухай хүсэлтийг уламжилж, худаг гаргах асуудлыг шийдвэрлэсэн.

Асран хамгаалагчаар тогтоолгох тухай 1 өргөдөлд сумын Засаг даргын 2022 оны 1/436 тоот албан бичгээр, Хүүхэд үрчлүүлэх тухай 1 өргөдөлд сумын Засаг даргын 2022 оны 1/388 тоот албан бичгээр тус тус хариуг өгсөн. Мах худалдан борлуулах цэг ажиллуулах тухай 1 өргөдлийн дагуу тухайн иргэнтэй 1 жилийн хугацаатай гэрээ байгуулж, зөвшөөрөл олгосон.

Улсын Алдарт уяач цолны мялаалганы наадамд 2 насны морь уралдуулах зөвшөөрөл хүссэн иргэний өргөдөлд сумын Засаг даргын 2022 оны 2/337 тоот албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн.

Засмал замыг сумын төвтэй холбосон 6,9 км хатуу хучилттай зам тавих ажил хийгдэж байгаатай холбогдуулан 22-р зөрлөгийн иргэдээс амьдрах орчны тав тухыг алдагдуулж байгаа талаар өргөдөл ирсний дагуу оршин суугчдад сумын Засаг даргын 2022 оны 1/373 тоот албан бичгээр хариуг өгсөн.

Буцалтгүй тусламж хүссэн 1 иргэний өргөдөлд буцалтгүй тусламж олгох боломжгүй талаар хариуг өгсөн. Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны 30 жилийн ойн хүрээнд “Хоршоолсон хэлбэрээр төгс дэлхийг бүтээе” уриан дор Говьсүмбэр аймагт зохион байгуулагдах зөвлөгөөнд сум орон нутгаа төлөөлж оролцоход Эрдэнэтолгойн булаг хоршооноос дэмжлэг хүссэн өргөдлийн дагуу сумын Засаг даргын 2022 оны А/83 дугаар захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс 400000 (дөрвөн зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл хүссэн 1 өргөдөлд сумын Засаг даргын 2022 оны А/97 дугаар захирамжаар зөвшөөрлийг олгосон.

Үйлчилгээний зориулалтын газрыг сунгах тухай 1 өргөдөл, Өвөлжөөний газрыг өөрийн эзэмшилд шилжүүлж өгөх тухай 1 өргөдөл, Давхардсан газрын асуудлыг шийдвэрлэж өгөх тухай 1 өргөдөл, Өвөлжөөний зориулалтаар газар хүсэх тухай 3 өргөдөл, Өвөлжөө, хаваржааны газар хүссэн 2 өргөдөл, Үйлчилгээний газар хүсэх тухай 1, Эзэмшлийн газрын талбайн хэмжээг сунгаж газар хүсэх тухай 1, Газар тариалангийн зориулалтаар газар эзэмшихийг хүссэн 1, өргөдлийг сумын 2023 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгаж, ИТХ-аар хэлэлцүүлэхээр төлөвлөөд байна.

“Малжуулах төсөл”-д хамрагдаж мал маллахыг хүссэн 1 иргэнтэй жилийн хугацаатай гэрээ байгуулж, 50 толгой малыг олгосон. Мөн төслийн мал маллах гэрээний хугацааг 1 жилээр сунгаж өгөх хүсэлт гаргасан 2 иргэний өргөдөлд 1 иргэний гэрээг дахин 1 жилээр сунгаж, 1 иргэн нь төслийн малыг 2 жил дараалан малласан тул гэрээг сунгах боломжгүй талаар хариуг өгсөн.

Бүрэн монгол төслийн багаас дэмжлэг хүссэн өргөдлийн дагуу сумын Засаг даргын 2022 оны А/98 дугаар захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс 500000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Хүснэгт №01

2022 оны 3-р улиралд иргэдээс сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт шийдвэрлэлтийн байдал

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт /хувь/
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болгоогүй	
1	Засаг даргын Тамгын газар	207	207		-	-	100
	Дүн	207	207		-	-	100

2022 оны 3-р улиралд иргэдээс сумын
Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт
хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт
/хэлбэрээр/

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт	Үүнээс:					
			Бичгээр	11-11 төвөөр	Цахим хэлбэрээр	Утсаар	Биечлэн уулзсан /амаар/	Бусад /иргэдтэй ажиллах-Нээлттэй өдөрлөгөөр/
1	Засаг даргын Тамгын газар	207	207	-	-	-	-	-
	Дүн	207	207	-	-	-	-	-

Хүснэгт №03

Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн агуулга /хувиар/
/хэлбэрээр/

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал /тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/
1	Засаг даргын Тамгын газар	Нийт 207 өргөдлөөс: - Иргэний бүртгэлтэй холбоотой 173 /83,6%/ - Бусад өргөдөл 34 /16,4%/

МЭДЭЭ ГАРГАСАН:

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ

Б.УУГАНБАЯР

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ